

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дөрөвдүгээр бүлгийн нэрийг “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах” гэж, 19 дүгээр зүйлийн нэрийг “Донороос эс, эд, эрхтнийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах” гэж, 20 дугаар зүйлийн нэрийг “Донорын эс, эд эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Донорын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн , 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалтын, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.1 дэх заалтын, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.4 дэх заалтын, , 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “цус,” гэснийг, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа” гэснийг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.1 дэх заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 6.1.3 дахь заалтын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 7.1.3 дахь заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 7.1.5 дахь заалтын “цусны аюулгүй байдал,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.3 дахь заалтын “цус сэлбүүлэх,” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.3 дахь заалтын “донор цус сэлбэсэн,” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх,” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх,” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн,” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүнийг экспортолж, импортолж” гэснийг тус тус хассугай

3 дугаар зүйл. Донорын тухай хуулийн Тавдугаар бүлгийг, 8 дугаар зүйлийг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.5 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.6 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.7 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.8 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.9 дэх заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтыг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7 дугаар хэсэг нэмсүгэй:

"7. Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учрах нөхцөл бий болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цусны донорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн Арван тавдугаар бүлгийн 15.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дугаар хэсэг нэмсүгэй:

"2. Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цусны донорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дор дурьдсан агуулгатай 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт нэмсүгэй:

“15.1.15.Цусны донорын үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив.”

2 дугаар зүйл. Энэ заалтыг Цусны донорын тухай хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ